



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2010 оны 12 сарын 09 өдөр

Дугаар 399

Улаанбаатар хот

Г “Жи Эс Би капитал ББСБ” ХХК-д 7  
банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх  
тусгай зөвшөөрөл нэмж олгох тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.3, 6.2.1, 22.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1, Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 186 дугаар тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 5.3 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. ”Жи Эс Би капитал ББСБ” ХХК-д банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж олгосугай.

2. Холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах, тусгай зөвшөөрөл нэмж олгосонтой холбогдуулан тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийлгэж, Улсын бүртгэлийн ерөнхий газарт холбогдох бүртгэлийг хийлгэсэн гэрчилгээ, ББСБ-ын дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг 2010 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор Хороонд ирүүлэхийг “Жи Эс Би капитал ББСБ” ХХК /П.Батхишиг/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бичил санхүүгийн газар /Н.Оюунчимэг/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН